



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/479

Ховд

“Ховд-Шигшмэл хурд-2019” хурдан морьдын
уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн морин спорт уяачдын “Алтайн унага” холбооны хүсэлтээр “Ховд Шигшмэл хурд-2019” хурдан морьдын уралдааныг 2019 оны 08 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд Бөөр хард зохион байгуулсугай.
2. Шигшмэл хурдан морины уралдаан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Хурдан морьдын уралдааныг тогтоосон хугацаанд “Монголын хурдан морьдын уралдааны дүрэм”, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг уралдаан зохион байгуулах ажлын хэсэг /Б.Ерөөлт/-т даалгасугай.
4. Хурдан морьдын уралдаан зохион байгуулах үеэр нийгмийн хэв журам сахиулах, хоггүй цэвэрхэн наадах, унаач хүүхдийн болон хурдан морины аюулгүй байдлыг хангах, худалдаа, үйлчилгээний соёл, стандарт, хүнсний бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг хангуулах зэрэг байгууллагынхаа үндсэн чиг үүргийн хүрээнд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, хариуцлагатай ажиллахыг Цагдаагийн газар /Б.Батзаяа/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Л.Батбаяр/, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /Ц.Номинчимэг/, Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /Б.Алтанбадралт/, Зэвсэгт хүчний 123 дугаар анги /М.Болдбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/ нарт үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 02261
D/Zax-A/479-Da



Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 23-ны өдрийн
А/479 дүгээр захирамжийн хавсралт

**“ХОВД-ШИГШМЭЛ ХУРД-2019” ХУРДАН МОРЬДЫН УРАЛДААН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- | | | |
|---------|----------------|--|
| Дарга: | Б.Ерөөлт | -“Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүн |
| Гишүүд: | Б.Батзаяа | -Цагдаагийн газрын дарга, хурандаа |
| | М.Болдбаатар | - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч |
| | Д.Батцэнгэл | - Мал эмнэлгийн газрын дарга |
| | П.Эрдэнэчулуун | - Мэргэжлийн хяналтын газрын дарга |
| | Ц.Номинчимэг | - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга |

Аймгийн “Алтайн унага” морин спорт, уяачдын холбооны тэргүүлэгчид

Нарийн бичгийн дарга: Д.Батхуяг - “Алтайн унага” морин спорт, уяачдын холбооны тэргүүлэгч

-oOo-